



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ
ХЭРЭГЖИЛТ 94 ХУВЬТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-01-
ШТА-ГА



Архангай аймаг

2025 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор Н.Энхчимэг

Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Аудитор Б.Азантунгалаг

Утас: 92091017 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn



Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	<ul style="list-style-type: none">➤ Товчилсон үгийн тайлбар3-4➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 5-7➤ Үндсэн мэдээлэл7➤ Аудитын тайлан8-21
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ Аудитор Н.Энхчимэг Б.Азантунгалаг 2025 оны 04 дүгээр сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	<p>БҮЛЭГ А. СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙНА</p> <p>А.1. Сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл арга хэмжээний 26.4 хувь нь жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.</p> <p>А.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, төсөвт үзүүлэх ачааллыг урьдчилж тооцоогүй байна.</p> <p>А.3 Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт бүрэн боловсруулсан байна.</p> <p>А.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн хуульд нийцсэн байна.</p> <p>БҮЛЭГ Б. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА</p> <p>Б.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.</p> <p>Б.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн бүрэн боловсруулж батлуулсан байна.</p> <p>Б.3 Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны 96.0 хувь нь тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон байна.</p> <p>БҮЛЭГ В. ТАХ-НЫ САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ОЛГОСОН БАЙНА .</p> <p>В.1. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавиагүй 9.9 сая төгрөгийн санхүүжилтийг зөрүүтэй тооцож олгосон байна.</p> <p>В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд төлөвлөсөн төсөл арга хэмжээний 94.3 хувийг хэрэгжүүлсэн байна.</p> <p>В.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4 их засварын ажлын гүйцэтгэгч ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг засварлах арга хэмжээ аваагүй байна.</p> <p>В.4. Тайлант онд 360.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.</p>



**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Дүгнэлт.....	22
Зөвлөмж	23
Холбогдох байгууллагын санал	24
Тайлан баталгаажуулсан тушаал.....	25-26
Хавсралт:Судалгаанууд	26-34



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<i>Товчлол</i>	<i>Тайлал</i>
МУЗГ	Монгол Улсын засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<i>Дугаар</i>	<i>Нэр</i>
Хүснэгт 1	2024 онд ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ
Хүснэгт 2	Сумын 2024 оны жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдал
Хүснэгт 3	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний жагсаалт
Хүснэгт 4	ОНТХО-аар олгосон ТАХ-ний санхүүжилт
Хүснэгт 5	Нягтлан бодох бүртгэл тайланд тусгагдах ТАХ
Хүснэгт 6	Өмнөх аудитаар шалгагдагч байгууллагад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт



АУДИТЫН НЭР:	“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”
АУДИТЫН КОД:	ГНАГ-2025/06-01-ШТА-ГА
АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийлээ.
АУДИТЫН ЗОРИЛТ:	<p>Архангай аймгийн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх;Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх;
АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:	ОНТХО, автозамын сангийн ТАХ-г хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, ГХБХБГ, ОНӨГ, Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат, Хайрхан, Цэцэрлэг сумын ЗДТГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг хийлээ.
АУДИТЫН АРГА ЗҮЙ:	Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан



шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг арга зүйг ашиглав.

**АУДИТАД
АШИГЛАСАН
ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ:**

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Авто замын тухай хууль,
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”
- ✓ Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар тогтоол, 2024 оны 07 дугаар тогтоол
- ✓ Эрдэнэбулган, Хашаат, Жаргалант, Хайрхан сумын Орон нутгийн 2024 оны төсөв баталсан болон тодотгож баталсан тогтоолууд

**АУДИТ
ХИЙСЭН
БАГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН,
ХУГАЦАА:**

Аудитыг Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, Б.Азантунгалаг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2025.02.26-2025.04.19-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

**АУДИТЫН
ТАЙЛАНГИЙН
БҮТЭЦ, ТҮҮНД
ТУСГАХ
МЭДЭЭЛЭЛ:**

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ. Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ангилагдан бичигдсэн болно.

**ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ:**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар 3,508.3 сая төгрөгийн 14 их завсрын ажлыг жагсаалтаар баталсан. Тайлангийн жилд аймгийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсвийн хэмжээг 102.6 сая төгрөгөөр бууруулан **3,405.7** сая төгрөгөөр тодотгон баталж,



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

гүйцэтгэлээр 13 их завсрын ажилд **3,134,3** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Салбараар хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо, олгосон санхүүжилтийн дүнгээр харуулбал:

№	Салбар	ТАХ-ний тоо	мөнгөн дүн	Хувь
1	Боловсрол салбар	9	2,082.4	66.4%
2	Соёл, урлаг салбар	2	515.7	16.5%
3	Бусад	2	536.20	17.1%
Нийт дүн		13	3,134,3	100.00%

Тайлант онд 5 сумын ИТХ-аар **837.5** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 33 төсөл арга хэмжээнд **711.3** сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Тухайлбал:

Сумдын хөрөнгө оруулалтын хувьд:

№	Сумдын нэр	ТАХ-ний тоо	Баталсан төсөв	Гүйцэтгэл	
				тоо	Мөнгөн дүн
1	Эрдэнэбулган сум	8	380.00	6	263.6
2	Жаргалант сум	8	141.30	8	141.2
3	Хашаат сум	12	181.50	12	176.9
4	Хайрхан сум	3	75.00	3	75.0
5	Цэцэрлэг сум	5	59.70	4	54.6
Нийт дүн		36	837.5	33	711.3

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтын тухайд:

Аймгийн ИТХ-ийн 2023 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 08 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар 1,157.6 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2024 оны 07 дугаар тогтоолоор Хайрхан сумын модон гүүрний засвар, Улсын чанартай авто замаас шинэ нэгдсэн эмнэлэг хүртэлх хатуу хучилттай авто зам, зогсоол, тохижилтын 2 ажлын төсвийг 240.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж гүйцэтгэлээр 1,273.6 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.



АУДИТЫН ТАЙЛАН

БҮЛЭГ А.

СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙНА

А.1. Сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл арга хэмжээний 26.4 хувь нь жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Тайлант онд аймаг, сумын ИТХ-аас ОНТХО, авто замын сангийн хөрөнгөөр 5,260.9 сая төгрөгийн 36 ТАХ-г хэрэгжүүлэхээр анх баталсан бөгөөд төсвийн тодотголоор 379.9 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг нэмж, нийт 53 ТАХ-ийг 5640.8 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт №1 2024 онд ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ /сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Анх баталсан		Тодотгосон		Өөрчлөлт	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО	13	3,508.30	14	3,405.70	1	(102.60)
2	Авто замын сан	1	1,157.60	3	1,397.60	2	240.00
3	Эрдэнэбулган сум	8	380.00	8	380.00	-	-
4	Хашаат сум	12	181.50	12	181.50	-	-
5	Жаргалант сум	-	-	8	141.30	8	141.30
6	Цэцэрлэг сум	2	33.50	5	59.70	3	26.20
7	Хайрхан сум	-	-	3	75.00	3	75.00
	Дүн	36	5,260.90	53	5,640.80	17	379.90

Эх сурвалж: аймаг, сумдын 2024 оны төсөв баталсан тогтоол

Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 53 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.4.1-т заасны дагуу аймаг, сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №2 Сумын 2024 оны жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдал /сая.төг/

№	Сумдын нэр	Нийт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний		Сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд				Авто замын тухай хуулийн дагуу		Тусгагдаагүй ТАХ-ний хувь(тоогоор)
				Тусгагдсан ТАХ		Тусгагдаагүй ТАХ				
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
1	Аймгийн ОНТХО	14	3,405.70	14	3,405.70	-	-	-	-	100%
2	Авто замын сан	3	1,397.60	-	-	-	-	3	1,397.60	100%
3	Эрдэнэбулган сум	8	380	8	380.00	-	-	-	-	100%
4	Хашаат сум	12	181.5	7	84.7	5	96.8	-	-	41.6%
5	Жаргалант сум	8	141.3	6	126.8	2	14.5	-	-	25.0%
6	Цэцэрлэг сум	5	59.7	0	5.1	5	54.6	-	-	0%
7	Хайрхан сум	3	75	1	20	2	55	-	-	66.6%
	Дүн	53	5,640.80	36	4,022.30	14	220.90	3	1,397.60	26.40%



Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 14 төсөл арга хэмжээ нь хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан, харин сумдад хэрэгжүүлсэн 36 ТАХ-ний 26.4 хувь нь буюу 14 ТАХ нь тухайн сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт №1-ээс үзэх)



Харин аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 2,297.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3¹, 24.4² дэх заалттай нийцэж байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 220.9 сая төгрөгийн 14 ТАХ нь сумын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдаагүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.4.1³ дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитаас сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй ТАХ-г төлөвлөсөн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг Хашаат, Цэцэрлэг, Хайрхан, Жаргалант сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

А.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, төсөвт үзүүлэх ачааллыг сумдын түвшинд урьдчилж тооцоогүй байна.

2023 онд Аймгийн Засаг даргаас төрийн өмчийн барилга байгууламжид судалгаа, хяналт шалгалт үзлэг хийх үүрэг даалгавар өгсний дагуу ГХБХБГ-ын даргын 2023 оны 09 сарын 11-ний өдрийн А/51 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн 19 сумын 173 барилга байгууламжид үзлэг шалгалт хийж дүгнэлт гарган барилга байгууламжийг үнэлж эрэмбэлсэн байна. Ажлын хэсгийн үнэлгээгээр аймгийн хэмжээнд 57-н барилга байгууламжид их засвар, 31 барилгад урсгал засвар нийт 88 барилга байгууламжид засвар хийх нэгдсэн дүгнэлт гаргаж, суурь судалгааны сантай болжээ.

2024 онд дээрх судалгааны дүнд үндэслэн аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 14 барилгын их засварыг 3,934.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хэрэгжүүлэхээр баталсан байна.


¹ 24.3.Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

² 24.4.Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

³ "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал"



Зураг-2 Аймгийн ГХБХБГ-аас 2023 онд хийсэн барилга байгууламжийн дүгнэлт



Эх сурвалж нь: ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаа

Харин Эрдэнэбулган, Хашаат, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан сумын ИТХ нь урсгал зардлын урьдчилсан тооцоолол хийгээгүй, нийгмийн ач холбогдлыг үнэлээгүй, 837.5 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээг ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталжээ.

А.3. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт бүрэн боловсруулсан байна.

“Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит”-аар аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлэхээр Засаг даргаас ирүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалтад ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй арга хэмжээ тусгасан зөрчлийг таслан зогсоож, зөрчил арилгуулах арга хэмжээ авснаар 2024 онд аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан 3,405.7 сая төгрөгийн 14 ТАХ, авто замын сангийн 1,397.6 сая төгрөгийн 3 ТАХ-ний ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилан боловсруулж баталсан байна.

Харин сумдад ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар, урсгал зардлын урьдчилсан тооцоолол хийгээгүй нийт 837.5 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴ дэх заалттай нийцэхгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний жагсаалт /сая төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	ИТХ-аар баталсан дүн		Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ	
		Тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО	14	3,405.70		
2	Авто замын сан	3	1,397.60		
3	Эрдэнэбулган сум	8	380.00	8	380.00
4	Хашаат сум	12	181.50	12	181.50
5	Жаргалант сум	8	141.30	8	141.30
6	Цэцэрлэг сум	5	59.70	5	59.70
7	Хайрхан сум	3	75.00	3	75.00
	Дүн	53	5,640.80	36	837.50

⁴ “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”



Аудитаар Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага, шалгуур хангаагүй ТАХ-г төлөвлөхгүй, батлахгүй байх албан шаардлагыг холбогдох сумын ИТХ, Засаг дарга нарт хүргүүллээ.

А.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн хуульд нийцсэн байна.

Аймаг, сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн 5,640.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 ТАХ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁵, 13.3⁶, 13.4⁷ дэх заалттай нийцсэн байна.

БҮЛЭГ Б.

**ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН
БАЙГУУЛСАН БАЙНА**

Б.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн ОНТХО, Авто замын сангийн тухайд: Аймгийн аймгийн ХААГазар нь 2024 оны ХАА-ны төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 6,232.5 сая төгрөгийн 17 ТАХ-ний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6⁸-д заасны дагуу tender.gov.mn цахим хуудсаар зохион байгуулсан байна.

Үнэлгээний хороо нь нийт 17 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 12 ТАХ-г анхны тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, 4 ТАХ-г 2 удаа тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. Харин аймгийн Музейн баруун сэмчингийн дээврийн засварын ажлын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар 2 удаа зарласан боловч гүйцэтгэгч оролцоогүй байна.

Сүмдын тухайд: ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан 837.5 сая төгрөгийн 36 ТАХ-ний худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн сумдын ЗДТГ-аас зохион байгуулжээ.

Аймаг, сумын ОНТХО, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нийт ТАХ-ний худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулсан байна. Үүнд:

Нийт 52 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа төсөвт өртөгт уялдуулан 21.1 хувь буюу 11 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар, 28.8 хувь буюу 15 ТАХ-г

⁵ 13.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална"

⁶ 13.3-д "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно"

⁷ 13.4-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно"

⁸ 45.6-д "Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 45.5-д заасан захиалагч өөрийн хэрэгцээнд худалдан авахаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж зохион байгуулна"



харьцуулалтын аргаар шалгаруулсан бол 50.1 хувийг шууд худалдан авах гэрээ байгуулжээ.

Эрдэнэбулган суманд хэрэгжүүлэх 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “1, 2 дугаар багийн үерийн далангийн зураг төсөв хийлгэх” 1 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Б.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн бүрэн боловсруулж батлуулсан байна.



ТБОНӨХБАУХАТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1⁹, 11.2¹⁰-т заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч шинээр хэрэгжүүлэх 6,694.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ тус бүрт үнэлгээний хороо байгуулж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу ТШӨХ, тендерийн баримт бичгийг боловсруулжээ.

Б.3 Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны 96.0 хувь нь тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон байна.

Аймгийн хэмжээнд ОНТХО-аар шинээр хэрэгжсэн 6,610.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ТАХ-ний худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулж тендерийн баримт бичигт заасан шаардлага хангасан 24 гүйцэтгэгчтэй 6,414.3 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулжээ.

Тендерийн баримт бичигт заасан санхүүгийн шаардлагыг хангаагүй дараах гүйцэтгэгчийг үнэлгээний хорооноос сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон зөрчил илэрлээ

Аудитын илрүүлэлт:

- ✓ Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн гал тогоо, эмэгтэй дотуур байрны их засварын ажлын АРАХААГ/20240101025 дугаартай тендерт санхүүгийн чадавхыг хангаагүй “Уужим цамхаг” ХХК-г сонгон шалгаруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5¹¹, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журмын” 3.2¹², Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн 18.1.1¹³ дэх заалттай нийцэхгүй байна.

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүллээ.

⁹ 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална”

¹⁰ 11.2-д “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”

¹¹ Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна

¹² Захиалагч, түүний томилсон үнэлгээний хороо хуулийн 52 дугаар зүйлд заасан үүргийг хүлээх ба худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, аргачлал, зааврыг дагаж мөрдөнө

¹³ “2022, 2023 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ батлагдсан төсөвт өртгийн 70 хувь болон түүнээс багагүй байна”




БҮЛЭГ В.

ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ-Г БҮРЭН ГҮЙЦЭТГҮҮЛСЭН БОЛОВЧ САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ОЛГООГҮЙ БАЙНА.

В.1 Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавиагүй 9.9 сая төгрөгийн санхүүжилтийг зөрүүтэй тооцож олгосон байна.

2024 онд аймаг, сумын ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 53 ТАХ-ний 47 ТАХ бүрэн хэрэгжиж 3 ТАХ нь он дамжин, 3 ТАХ огт хэрэгжээгүй байна.

Бүрэн хэрэгжсэн 47 ТАХ, он дамжин хэрэгжих 3 ТАХ-ний гүйцэтгэлд 5,119.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.



Хүснэгт №4 ОНТХО-аар олгосон ТАХ-ний санхүүжилт/сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	ИТХ-аар баталсан дүн		Гэрээний дүн		Тайлант онд олгосон санхүүжилт				Тайлант онд хэрэгжээгүй ТАХ	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тайлант онд хэрэгжиж дууссан ТАХ		Он дамжин хэрэгжих ТАХ		Тоо	Мөнгөн дүн
						Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн		
1	Аймгийн ОНТХО	14	3,405.70	13	3,755.90	11	2,494.00	2	640.30	1	50.00
2	Аймгийн авто замын сан	3	1,397.60	3	2,249.30	2	1,073.60	1	200.00		-
3	Эрдэнэбулган сум	8	380.00	6	270.20	6	263.60			2	95.00
4	Хашаат сум	12	181.50	12	176.80	12	176.90				
5	Жаргалант сум	8	141.30	8	141.20	8	141.20				-
6	Цэцэрлэг сум	5	59.70	5	54.60	5	54.60				
7	Хайрхан сум	3	75.00	3	75.00	3	75.00				
	Дүн	53	5,640.80	50	6,723.00	47	4,278.90	3	840.30	3	145.00

Он дамжин хэрэгжих 3 ТАХ нь:

- ✓ Хашаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилга, спорт заалны засвар, 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын их засвар 680.0 сая төгрөг,
- ✓ Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заалны их засвар 490.0 сая төгрөг,
- ✓ Улсын чанартай авто замаас Нэгдсэн эмнэлэг хүртэлх хатуу хучилттай авто зам, зогсоол 1,098.9 сая төгрөг

Аймгийн тухайд: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13 төсөл арга хэмжээнд 3,134.3 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний дагуу олгож, 103.4 сая төгрөгийг техник хяналтын зардал, чанарын баталгаа болгож хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант жилд хэрэгжсэн 13 төсөл арга хэмжээнд зураг төсөв, ажлын даалгаврын дагуу захиалагч байгууллагыг төлөөлж аймгийн ГХБХБГ-ын хяналтын инженер хяналтыг хэрэгжүүлж,



гүйцэтгэлийн төсвийг аймгийн ХБТХОХ, СТСХ-т хүргүүлдэг боловч зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг илүү олгосон, төсвийн хэмнэлтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 дүгээр сургуулийн дотор халаалтын иж бүрэн засвар, 13-р цэцэрлэгийн барилгын их засварын ажлуудаас 8.1 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн,
- ✓ Аймгийн ОНТХО-аар гүйцэтгэсэн “1 дүгээр сургуулийн дотор байрны халаалтын иж бүрэн засвар”-ын ажлыг гүйцэтгэсэн Эсгэл ХХК-д 0.3 сая төгрөгийн илүү санхүүжилтийг олгосон,

Сумдын тухайд: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 суманд 711.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл арга хэмжээ хэрэгжсэний, 365.1 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээ нь их засвар, 311.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл арга хэмжээ нь тоног төхөөрөмж, 25.1 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ нь ТЭЗҮ, 35 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь урсгал зардалд тус тус зарцуулагджээ.

Тухайлбал:

- ✓ Архангай аймгийн Хашаат, Жаргалант, Хайрхан сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн 397.7 сая төгрөгийн 23 төсөл арга хэмжээнд захиалагчийн үе шатны болон байнгын хяналтыг хэрэгжүүлээгүй, ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй,
- ✓ Эрдэнэбулган сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн 4 дүгээр багийн төв, өрхийн эмнэлгийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгүүлэхээр “Төгс шийдэл ойл” ХХК-тай 28.0 сая төгрөгийн ААЭБСЗДТГ/20240201006 тоот гэрээ байгуулан ажил гүйцэтгэх явцад ажлын даалгаварт тусгаагүй ажил хийсэн шалтгаанаар 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр нэмэлт гэрээ байгуулан төсвийг 1.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Илүү олгосон санхүүжилтийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх албан шаардлагыг Аймаг, сумын Засаг дарга нарт хүргүүллээ.

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд төлөвлөсөн төсөл арга хэмжээний 94 хувийг хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 6,723.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 50 төсөл арга хэмжээнээс тайлант онд бүрэн хэрэгжсэн 5,376.1 сая төгрөгийн 35 ТАХ-г улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад хүлээн авч гэрээг дүгнэсэн бол авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 ТАХ гэрээний дагуу он дамжин хэрэгжихээр байна.

Тайланд онд хэрэгжүүлсэн 1,346.9 сая төгрөгийн 14 ТАХ-ний гэрээг дүгнээгүй байна.Үүнд:

- ✓ Хашаат сумын “Ерөнхий боловсролын сургуулийн барилга, спорт заалны засвар, 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын их засвар”,



- ✓ Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заалны их засвар,
- ✓ Хашаат сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн 181.5 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар 46.1.6¹⁴, МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.6¹⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7.9¹⁶ дэх заалттай тус тус нийцээгүй байна.

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж холбогдох арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ, Хашаат сумын засаг даргад хүргүүллээ.

В.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4 их засварын ажлын гүйцэтгэгч ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг засварлах арга хэмжээ аваагүй байна.

Аймаг, сумдын ОНТХО, авто замын сангийн хөрөнгөөр бүрэн хэрэгжиж улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан 47 ТАХ, он дамжин хэрэгжих 3 ТАХ-ний ашиглалтын байдлыг зураг төсөв техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн эсэхийг тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ "Цагаан сүмбэр" ХХК-ны гүйцэтгэсэн 490.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өлзийт сумын “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заалны их засвар”-ын ажлын хана таазнаас нэвчилт үүссэн, спорт заалны байрны төв хаалгыг шинэчлээгүй, өлгүүр хувцас солих өрөөний дээврийг засварлаагүй байна.

Зураг-5 “Өлзийт сумын “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заал”-ны их засвар



- ✓ "Цагаан сүмбэр" ХХК -ны гүйцэтгэсэн 680.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй Хашаат сумын “Ерөнхий боловсролын сургуулийн “Спорт заал дотуур байрны их засвар” нь дулаан алдагдал ихтэй, дээвэр хэсэг нь зайтай дусаал дусаж, шороо тоос ордог, хана таазанд нэвчилт үүссэн.

¹⁴ Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавих...

¹⁵ Захиалагч ... гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, ... ажиллана

¹⁶ Төсөл, арга хэмжээний гэрээ дуусгавар болох, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад гэрээ дүгнэсэн актыг энэ журмын 16 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргах бөгөөд эцсийн санхүүжилтийн хүсэлтэд эх хувиар хавсаргана



Зураг-6 Хашаат сумын “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заал”-ны их засвар



- ✓ "Уужим цамхаг" ХХК-ны гүйцэтгэсэн 363.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэг сумын “Ерөнхий боловсролын сургуулийн гал тогоо, эмэгтэй дотуур байрны их засвар”-ын ажлын гүйцэтгэлийг шалгахад гал тогоо, дотуур байрны барилгад мөөгөнцөр үүссэн, дулаан алдагдал ихтэй, гал тогооны зориулалтаар ашиглах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Зураг-7 Цэцэрлэг сумын “Ерөнхий боловсролын сургуулийн гал тогоо, эмэгтэй дотуур байрны их засвар”



- ✓ “Сайхан тэрх” ХХК-ны гүйцэтгэсэн Өндөрсант багийн “Соёлын төвийн их засвар”- 136.4 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл нь заалны шал ховхорч ашиглалтын шаардлага хангахгүй нөхцөл байдал үүссэн байна.

Хөрөнгө оруулалтын ажлыг чанаргүй, дутуу хийсэн гүйцэтгэгч нараар зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах албан шаардлагыг ГХБХБГ-т хүргүүлэв.

В.4 Тайлант онд 360.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 3,269.1 сая төгрөгийн 44 ТАХ-г байнгын ашиглалтад хүлээн авч, 360.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1, 4.1.4, 4.4 дэх заалттай нийцэхгүй байна.



Хүснэгт №5. Нягтлан бодох бүртгэл тайланд тусгаагдах ТАХ /сая.төгрөг/

ДД	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглалтад хүлээн авсан ТАХ		НББ-д тусгасан ТАХ		НББ-д тусгаагүй ТАХ	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО	10	2,551.30	8	2,190.8	2	360.5
2	Эрдэнэбулган сум	6	270.20	6	270.20		
3	Хашаат сум	12	176.80	12	176.80		
4	Жаргалант сум	8	141.20	8	141.20		
5	Хайрхан сум	3	75.00	3	75.00		
6	Цэцэрлэг сум	5	54.60	5	54.60		
Дүн		44	3,269.10	42	2,908.6	2	360.5

Аудитын илрүүлэлт:

Байнгын ашиглалтад хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй арга хэмжээнүүд:

- ✓ Аймгийн 2024 оны ОНТХО-аар хэрэгжсэн Хотонт сумын Өндөрсант багийн Соёлын төвийн барилгын их засварын 136.4 сая төгрөг,
- ✓ Батцэнгэл сумын ЕБС-ын дотуур байрны их засварын 224.1 сая төгрөг төгрөгийн их засварын ажил

Аудитаас барилгын их засварын ажлыг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ 64.7 ХУВЬТАЙ БАЙНА.

Өмнөх аудитаар аймаг, Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумын ИТХ, засаг дарга, аймгийн ОНӨГ-т хүргүүлсэн 16 албан шаардлагын хэрэгжилтийг энэ удаагийн аудитаар давтан шалгахад Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж баталсан, ТАХ-д үе шатны хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргаж өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт №6 Өмнөх аудитаар шалгаагдагч байгууллагад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт /сая.төг/

№	Байгууллагын нэр	Шалгаагдагч байгууллагад хүргүүлсэн		Хэрэгжсэн		Хэрэгжээгүй	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ИТХ	1		1			
2	Эрдэнэбулган сумын ИТХ	1				1	
3	Жаргалант сумын ИТХ	1				1	
4	Хашаат сумын ИТХ	1				1	
5	Аймгийн Засаг дарга	1	1,011.6	1	1,011.6		
6	ОНӨГ	1	300.9	1	300.9		
7	Эрдэнэбулган сумын ЗДТГ	4	1,082.8	3	1,014.7	1	68.1
8	Жаргалант сумын ЗДТГ	3	56.9	3	56.9	1	
9	Хашаат сумын ЗДТГ	3	134.0	2	134.0	1	
Дүн		16	2,586.2	11	2,518.1	6	68.1



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аймаг сумын 2024 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаас **“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ 94 ХУВЬТАЙ БАЙНА”** гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөөд байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох баримтад үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.
Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл арга хэмжээний 26.4 хувь нь сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
2. Сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үр ашгийн урьдчилсан тооцоолол хийгээгүй, төсөвт үзүүлэх ачааллыг урьдчилж тооцоогүй, ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаваргүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж хууль зөрчсөн байна.
3. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч тендерийн баримт бичигт заасан шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон байна.
4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавиагүй 9.9 сая төгрөгийн санхүүжилтийг зөрүүтэй тооцож олгосон байна.
5. Байнгын ашиглалтад хүлээн авсан 360.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.
6. Аймгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 1663.7 сая төгрөгийн 4 ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн байна.
7. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийн 64.7 хувийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргасан байна.

-----oOo-----



Аудитын дүн: Аудитаар нийт 3,663.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох 26 албан шаардлага 3 төлбөрийн акт тогтоож холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

ХАВСРАЛТ №1 ОНТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээ Аймаг, сумын урт, дунд, богино хугацааны мөрийн хөтөлбөрийн уялдаа

ДД	Төсөл, арга хэмжээний нэр	2024 онд санхүүжих дүн	Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	Хэрэгжилтийн хувь	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ны	
						Тоо	Мөнгөн дүн
1	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Архангай, Эрдэнэмандал сум/	0.30					
2	1 дүгээр сургуулийн дотор халаалтын иж бүрэн засвар /Эрдэнэбулган сум/	391.50	2.3.12	2.1.1.5	100%		
3	Цэцэрлэгийн барилгын монтажны засвар /Булган сум/	63.30	2.3.12		0%		
4	13-р цэцэрлэгийн барилгын их засвар /Эрдэнэбулган сум/	151.60	2.3.12	1.1.1.4	100%		
5	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны гадна халаалтын 110 м шугамын засвар /Булган сум/	53.90	2.3.12	2.1.1.7	100%		
6	Ерөнхий боловсролын сургуулийн гал тогоо, эмэгтэй дотуур байрны их засвар /Цэцэрлэг сум/	357.40	2.3.16	2.1.1.11	100%		
7	Хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засвар /Тариат сум/	215.20	2.3.12	1.1.1.5	100%		
8	Соёлын төвийн барилгын их засвар /Ихтамир сум/	381.60	2.5.5	9.1.2.11	100%		
9	Ерөнхий боловсролын сургуулийн барилга, спорт заалны засвар, 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын их засвар Хашаат сум/	400.30	2.3.13		0%		
10	Дотуур байр, спорт заалны их засвар /Өлзийт сум/	240.00	2.3.13	2.1.1.9	100%		
11	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засвар (Батцэнгэл сум)	209.10	2.3.16	2.1.1.10	100%		
12	Өндөрсант багийн соёлын төвийн барилгын их засвар (Хотонт сум)	134.10	2.5.5	9.1.2.12	100%		
13	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэврийн засвар /Аймаг	511.10					
14	Их засварын ажлын зураг төсөв	24.10					
Аймгийн ОНТХО-ын нийт дүн		3,133.50	-	-		-	
15	Багийн захиргааны компьютер тоног төхөөрөмж Эрдэнэбулган сум	23.5					
16	3 дугаар багийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт хийх Эрдэнэбулган сум	36.5	2.5.5	1.5.2	100%		
17	Автобусны буудлуудын зогсоол тохижилт хийх Эрдэнэбулган сум	129.3	2.3.3	2.3.4	100%		
18	Төрийн үйлчилгээний КИОСК машин, тоног төхөөрөмж Эрдэнэбулган сум	24.4			0%		
19	4-р багийн төв , өрхийн эмнэлгийн цэвэр бохир усанд холбох хийх Эрдэнэбулган сум Эрдэнэбулган сум	29.5	2.3.2	1.1.3	100%		
20	5-р сургуулийн өргөтгөлийн зураг төсөв Эрдэнэбулган сум	0					
21	1,2 багуудын үерийн далангийн зураг төсөв Эрдэнэбулган сум	0					
22	Арманал өрхийн эмнэлгийн засварт Эрдэнэбулган сум	19.5	2.3.1	1.1.2	100%		
Эрдэнэбулган сумын нийт дүн		262.70				0	-
23	ЗДТГ-ын албан хаагчдад тоног төхөөрөмж Жаргалант сум	12.50			0%	1	12.50
24	ЗДТГ-т авто машинд зуны дугуй худалдан авах Жаргалант сум	2.00			0%	1	2.00
25	ЗДТГ-т ёслол хүндэтгэлийн гэр худалдан авах Жаргалант сум	60.00	2.3.4	2.4.7	100%		
26	Урлагийн тайз шинээр барих Жаргалант сум	20.00	2.5	2.4.5	100%		
27	Наран мишээсэн баялаг хангай ном Жаргалант сум	5.50	2.4.7	2.4.7	100%		
28	Хорвоод хосгүй нутаг мину альбом Жаргалант сум	10.00	2.4.7	2.4.7	100%		
29	100 жилийн ойд зориулж бүтээсэн ном Жаргалант сум	13.00	2.4.7	2.4.7	100%		
30	ЕБС-ын сургалтын орчин бүрдүүлэх Жаргалант сум	18.30	2.3.10	2.3.10	100%		



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Жаргалант сумын нийт дүн		141.30				2	14.50
31	Тамгын газрын дээврийн засвар Хашаат сум	20.00			0%	1	20.00
32	Гэрэлтүүлэг Хашаат сум	10.30	3.3.1	3.3.1	100%		
33	Тоног төхөөрөмж Хашаат сум	15.00			0%	1	15.00
34	Сургуулийн спорт заалны шалны засвар Хашаат сум	16.00	1.2.3	1.2.3	100%		
35	Соёлын төвд гэр авах Хашаат сум	5.00			0%	1	5.00
